





ТҮМЭН ШУВУУТ®
Аз жаргалыг үйлдвэрлэнэ

2024

**БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**



**УЛААНБААТАР ХОТ, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ
27-Р ХОРОО , 21-Р ХОРООЛОЛ №59**

**УЛААНБААТАР ХОТ
2024 ОН**

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ДААЛГАВАР2023 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

**Түмэн шувуут ХК-д
Зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ
авахуулах тухай**

Нийслэлийн Байгаль орчны газрын хяналтын хэлтсийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч А.Сарнай би НБОГ- 261 дугаартай гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахад Түмэн шувуут ХК нь Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар батлуулж хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнаагүй нь Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 /Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно/, 9.8 /Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална/, 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь /Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах/ тул дээрх хууль бус үйлдлээ зогсоож, цаашид байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар батлуулж, биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнаж зөрчлөө арилгах арга хэмжээг авч хуулийн хугацаанд хэрэгжүүлж ажиллахыг даалгаж байна.

Даалгаврыг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор биелүүлэхийг Д.Ганпүрэвд даалгаж, тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэх болохыг мэдэгдэв.

Зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээний зардлыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд, 18 насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгч хариуцна.

ЭРХ БҮХИЙ АЛБАН
ТУШААЛТАН:

А.САРНАЙ

ДААЛГАВРЫГ ХҮЛЭЭН
АВСАН:

Д.ГАНДҮРЭВ



ШИЙТГЭЛИЙН ХУУДАС (маягт 2)

..... оны .. сарын .. өдөр

№ 0612375

..... хот, сум

ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭХ ЗӨРЧИЛД ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ ТУХАЙ

..... /эрх бүхий албан тушаалтны харьяалах байгууллага, ажил, нэр, цол, зэрэг/ би Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан .. асуудлыг шалгаад ОЛСОН нь:

Холбогдогч /харьяалах улс, хуулийн этгээдийн нэр, хүний овог, нэр, регистр/паспортын дугаар, ажил, албан тушаал, хаяг/ -нь

болох нь зэрэг нотлох баримтаар нотлогдон тогтоогдож, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэх боломжтой байна.

Иймд холбогдогч /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн зүйлийн -д заасан шийтгэл оногдуулах үндэслэлтэй байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлд заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Холбогдогч /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн /зүйл, хэсэг, заалт/-д заасны дагуу /шийтгэлийн төрөл, хэмжээ/ шийтгэл оногдуулсугай.

2. Оногдуулсан шийтгэлийн 500,000 төгрөгийг Төрийн сангийн 100200000906 цот дансанд, хохирол, нөхөн төлбөрийн төгрөгийг Төрийн сангийн тоот дансанд, зөрчил үйлдэж олсон мөнгөн орлогыг /улсын төсөвт/ Төрийн сангийн тоот дансанд тус тус шийтгэлийн хуудсыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор бэлнээр, бэлэн бусаар сайн дураар төлж биелүүлэхийг даалгасугай.

3. Зөрчлийн тухай хуулийн 3.6 дугаар зүйлд зааснаар хүн, хуулийн этгээдийн /үйл ажиллагаа, эрх/ аль болохыг зурах/-ыг хугацаагаар /хязгаарлах, хүчингүй болгох/ аль болохыг зурах/ эрх хасах шийтгэл оногдуулсугай.

4. Торгуулийн шийтгэлийг хэсэгчлэн төлүүлэх үндэслэл тогтоогдсон тул оногдуулсан төгрөгийн торгуулийн шийтгэлийг хувийг хугацааны дотор, хувийг хугацааны дотор, хувийг хугацааны дотор хэсэгчлэн сайн дураараа биелүүлэхийг даалгасугай.

5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.5 дугаар зүйлд заасны дагуу хураан авсан:

- А. Зөрчил үйлдэж олсон /хөрөнгө, орлого/, /аль нь болохыг доогуур зурах/
- Б. Зөрчил үйлдэхэд ашигласан /зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга/, /аль нь болохыг доогуур зурах/
- В. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой баримт болох /эд зүйл, баримт бичиг/ /аль нь болохыг доогуур зурах/ /нэр, төрөл, тоо, хэмжээ, шинж тэмдэг/-г Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.12 болон Засгийн газрын тогтоолоор баталсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын дагуу шийдвэрлэсүгэй.

6. Холбогдогч /хүн, хуулийн этгээдийн нэр/-д Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар -ны өдрийн дотор үүргийг нөхөн биелүүлэхийг даалгах, эсхүл үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой төгрөгийн зардлыг гаргуулсугай.

7. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасан харьяалах шүүхэд хүсэлт гаргана.

8. Шийдвэрийг эс зөвшөөрвөл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ШИЙДВЭР ГАРГАСАН:

Эрх бүхий албан тушаалтан /..... / (нэр)

ТАНИЛЦСАН:

Холбогдогч /..... / (сарын үсэг) (нэр)



..... оны .. сарын .. өдөр

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000576156047

Системийн огноо/System Date: 2023.10.30 16:06:10

| Дт/From | Дансны/Картын дугаар Account/Card number | Нэр/Name | Дүн/Amount | Ханш/Rate |
|------------------------------|---|-------------------------------|----------------|-----------|
| | 5166226977 | ТҮМЭНШУВУУТ | 500,000.00 MNT | 1.00 |
| / Таван зуун мянган төгрөг / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No | Банкны нэр Bank Name | | |
| | 90 | Төрийн Сан | | |
| | Дансны/Картын дугаар Account/Card number | Нэр/Name | | |
| | 100200000906 | НБОГ.Хүү торгуулийн орлого | 500,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-2844753 Түмэншувуут ХК-с НБОГ

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

АГУУЛГА

Нэг. Төслийн товч танилцуулга

- 1.1. Төслийн тодорхойлолт
- 1.2. Орчны агаарын чанар
- 1.3. Хөрсний шинжилгээ
- 1.4. Усны чанарын шинжилгээ
- 1.5. Хог хаягдалын эх үүсвэр, хэмжээ

Хоёр. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Гурав. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө, БОМТ-ний тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

- 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- 3.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
- 3.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- 3.4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
- 3.5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- 3.6. Удирдлага, зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө
- 3.7. Олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь



НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн тодорхойлолт

| | |
|------------------------------------|---|
| Төслийн нэр: | Шувууны аж ахуй болон тэжээлийн үйлдвэрийн цогцолбор |
| Төсөл хэрэгжүүлэгч: | “Түмэн шувуут” ХК |
| Утас: | 70005225 |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9010002006 РД: 2844753 |
| Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: | Хан-Уул дүүрэг, 13-р хороо, Туул тосгон, Шувуун фабрик ТШ-1 СХД, 21-р хороо Их булагийн ам ТШ-2 СХД, 21-р хороо Хужиртын даваа, 361-ийн гарам Тэжээлийн үйлдвэр Сонгино хайрхан дүүрэг 27-р хороо 21-р хороолол №59 тоот Оффис, Савалгааны үйлдвэр |
| Төслийн зорилго, онцлог: | Шувуугаа өөрсдийн үйлдвэрлэсэн чанарын шаардлага хангасан тэжээлээр тэжээж бойжуулхаас гадна шувууны сангасаа бордоо болгон ашиглаж байгаль ээлтэй эко үйлдвэрлэл явуулхыг зорьж байна. Шувууны аж ахуйгаас бэлтгэн нийлүүлж буй “Түмэн” нэрийн 21 төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн сэтгэлд таашаагдсан, эрэлт ихтэй, шинэхэнээрээ хэрэглэгчдийн гарт хүрдэг нь ажлын онцлог юм. |
| Хүчин чадал: | ТШ-1 320,000 өндөглөгч тахиатай, өдөрт 270,000 өндөг үйлдвэрлэх, ТШ-2 114,000 өндөглөгч тахиатай, өдөрт 85,500 өндөг үйлдвэрлэх, Нийтдээ 434,000 өндөглөгч тахиатай, өдөрт 355,500 өндөг үйлдвэрлэдэг. Тэжээлийн үйлдвэр нь цагт 8-10тн, өдөрт 100тн бүрэн найрлагат багсармал тэжээл үйлдвэрлэнэ. Савалгааны үйлдвэр нь хоногт 355,500 өндөг савлах, борлуулах |
| Ажиллах хоног: | 365 |
| Ажиллах хүч: | 250 |
| Төслийн байршил: | Хан-Уул дүүрэг, 13-р хороо, Туул тосгон, Шувуун фабрик ТШ-1 СХД, 21-р хороо Их булагийн ам ТШ-2 СХД, 21-р хороо Хужиртын даваа, 361-ийн гарам Тэжээлийн үйлдвэр Сонгино хайрхан дүүрэг 27-р хороо 21-р хороолол №59 тоот Оффис, Савалгааны үйлдвэр |
| Эзэмшил газрын хэмжээ: | |
| Ус хангамж: | Оффис болон савалгааны үйлдвэр төвийн шугам, бусад аж ахуй үйлдвэр гүний худгийн усаар хангадаг. |
| Дулаан хангамж: | Оффис болон савалгааны үйлдвэр төвийн халаалттай холбогдсон, бусад аж ахуй үйлдвэр усан халаалтын зуухаар халуун ус, дулаан үйлдвэрлэж хангадаг. |
| Цахилгаан хангамж: | Төвийн шугам сүлжээнд холбогдсон. |
| Бохирын шийдэл: | Оффис болон савалгааны үйлдвэр төвийн шугамд холбогдсон, бусад аж ахуй, үйлдвэрүүд төвлөрсөн хуримтлуулах ёмкостьд цуглуулах ба соруулна. |





Зураг 1. Шувууны аж ахуйн орчны схем зураг

Төслийн талбайн байршил: “Түмэн шувуут” ХК-ийн “Шувууны аж ахуйн цогцолбор” төсөл нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, 13-р хороо, Туул тосгон, хуучнаар Шувуун фабрикт L-48-10 хэлбэртэй хавтгайд 14.4га талбайг хамран байрлах бөгөөд Улаанбаатар хот болон төвийн бүсийн аймгуудтай авто замаар холбогдсон дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутаг вm.



| | |
|---------------------|--------------------------|
| Сэдэв: | Байршил |
| Захиалагч: | "Түмэншувуут" ХК |
| Гүйцэтгэгч: | "Цагаан уулын оргил" ХХК |
| Он: | 2020 |
| Координатын систем: | WGS 1984 UTM ZONE 48N |
| Эх сурвалж: | Terra Incognita 2.45 |

Зураг 2. Төслийн талбайн байршил

(Эх сурвалж: Google Earth)





Зураг 3. Шувууны аж ахуй-2 орчны схем зураг

Төслийн талбайн байршил: “Түмэн шувуут” ХК-ийн “Шувууны аж ахуйн цогцолбор-2” төсөл нь Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүрэг 21-р хороо Их булагийн ам 20га талбайг хамран байрладаг.





Зураг 4. Төслийн талбайн байршил (Шувууны аж ахуй-2)

Төслийн хүчин чадал: Үйлдвэрийн хүчин чадлыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Үйлдвэрлэлийн хүчин чадал

| Нэгж хэсэг | Тоо ширхэг | Хүчин чадал жилээр |
|----------------------------------|------------|--|
| Өндөглөгч шувууны байр | 12 | Суурилагдсан хүчин чадал: 417900 толгой шувуу өсгөх |
| Дэгдээхийн байр | 3 | Нийт 120000 толгой дэгдээхий бойжуулах, өсгөвөрлөх |
| Сав баглааны үйлдвэр | 1 | Цагт 600-800 ширхэг үүр, жилд 4 сая ширхэг үүр үйлдвэрлэх |
| Бордооны үйлдвэр | 1 | Хоногт 47-94м ³ , жилд 1000-1500тн органик бордоо |
| Тахианы мах боловсруулах үйлдвэр | 1 | Хоногт 6000-8000 толгой шувуу нядлах |
| Тэжээлийн үйлдвэр | 1 | Цагт 8-10тн, жилд 15,000тн мал амьтны тэжээл үйлдвэрлэх |
| Инкубатор | 1 | Нийт 153600 ширхэг үржлийн өндөг дарах |

- 1. Өндөглөгч тахианы байр:** Өндөглөгч тахианы амьдрах, өндөглөх таатай орчин нөхцөлийг хангасан дулаан, чийгшил, гэрэлтүүлэг, агааржуулалттай байр байна. Өндөг түүх, бохир сангасыг гадагшлуулан зайлуулах, тэжээл хангах болон ундны ус олгох бүрэн автомат системтэй.





Зураг 5. Өндөглөгч шувууны байр



Зураг 6. Өндөглөгчийн байрны дотор зохион байгуулалт

(Өндөг түүх систем, тэжээл олгох, сангас зайлуулах, дулаан, чийгшил автомат хяналтын төхөөрөмж)

- 2. Дэгдээхийн байр:** Дэгдээхийг нас бие хүртэл хугацаанд өсгөхөд таатай орчин нөхцөлийг хангасан дулаан, чийгшил, гэрэлтүүлэг, агааржуулалттай. Тэжээл болон ундны ус олгох, бохир сангасыг гадагшлуулах бүрэн автомат системтэй.



Зураг 7. Дэгдээхийн байрны гадна болон дотор зохион байгуулалт

(Тэжээл олгох, сангас зайлуулах, дулаан, чийгшил автомат хяналтын төхөөрөмж)

- 3. Сав баглааны үйлдвэр:** Хаягдал бор, цагаан цаасыг дахин боловсруулж өндөгний цаасан үүр үйлдвэрлэдэг ба цагт 600-800 ширхэг, өдөрт 16-20.0 мянган ширхэг өндөгний үүр сав үйлдвэрлэх хүчин чадалтай.



Зураг 8. Сав баглааны үйлдвэр

Өндөгний сав баглааны үйлдвэр нь БНХАУ-ын Наня машин ХХК-ийн хаягдал цаасыг боловсруулан өндөгний цаасан үүр үйлдвэрлэх бүрэн автомат төхөөрөмж юм. Бор болон цагаан хаягдал цаасыг 50:50 харьцаатай боловсруулан хэвлэж цельсийн 400 градуст хатааж ариутгадаг. Үйлдвэрлэсэн цаасан үүрийг дотоодын хэрэгцээнд ашиглахаас гадна бусад аж ахуйн нэгжүүдэд нийлүүлдэг. Тухайлбал 2020 онд нийт үйлдвэрлэсэн цаасан үүрний 30%-ийг худалдан борлуулсан байна.

Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. Сав баглааны үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хүчин чадал


| Загвар | Хүчин чадал ш/ц | Хэвлэгчийн хэмжээ | Хатаагч | Үйлдвэрийн хэмжээ |
|--------|-----------------|-------------------|-------------|-------------------|
| ЕС1000 | 1000 | 1600*400мм | 16*2.6*2.4м | 25*12*4.5 |

4. **Сангасны бордооны үйлдвэр:** Шувууны аж ахуйгаас хаягдах сангасыг дахин боловсруулж органик компост бордоо үйлдвэрлэдэг ба хоногт 47-94м³, жилд 1000-1500м³ компост бордоо үйлдвэрлэх хүчин чадалтай.



Зураг 9. Сангасны бордооны үйлдвэр

5. **Тахианы мах боловсруулах үйлдвэр:** 650-аас дээш хоногийн настай өндөглөгч тахианы өндөглөх чадвар мууддаг тул өсвөр тахиагаар сүрэг сэлбэх ажил жил бүр хийгддэг. Хоногт 8,000 толгой өндөглөгч тахиа нядлах хүчин чадалтай бүрэн автомат үйлдвэртэй. Өндөглөх чадвар муудсан тахиаг жилд 4 удаа багадаа 30,000мян.ш нядлаж “Мах импекс” ХК болон зарим хувь иргэдэд гэрээгээр мах нийлүүлдэг.
6. **Мал амьтан, шувууны тэжээлийн Агрофийд үйлдвэр:** Цагт 8-10тн, жилд 15,000тн малын болон тахианы тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай. Уг үйлдвэрт улаан буудай, овьёос, хивэг, өвсний гурил, рапсын шахдаш, ургамлын /рапсын тос, шохойн чулуу, шүү давс зэрэг дотоодын түүхий эд болон эрдэнэшиш, шар буурцаг, үл орлогдох аминхүчил, витаминь бэлдмэлийг гадаадын нэр хүндтэй харилцагч байгууллагуудаас авч өсвөр шувуу, өндөглөгч тахианы 7 нэр төрлийн тэжээл, 6 нэр төрлийн малын тэжээл үйлдвэрлэж зах зээлд амжилттай нэвтрүүлээд байна.



Зураг 10. Агрофийд тэжээлийн үйлдвэр



Зураг 11. Бүтээгдэхүүний нэр төрөл

- 7. Үржлийн өндөг дарах инкубатор:** Үр тогтсон үржлийн өндгийг технологи горимын дагуу 21 хоног дарж дэгдээхий гаргах инкубатор.



Зураг 12. Инкубатор дотор зохион байгуулалт

(дүлаан, чийгшил тохируулах автомат төхөөрөмж)

- 8. Чанарын хяналтын лаборатори:** Хими-микробиологийн иж бүрэн лаборатори нь MNS ISO 17025:2007 стандартын дагуу итгэмжлэлд хамрагдан үйл ажиллагаагаа баталгаажуулах ба түүхий эд, туслах материалын хяналт шинжилгээг нийлүүлэлт бүрт, технологийн хэсгүүд болон бэлэн бүтээгдэхүүний цуврал тутамд шинжлэн Монгол улсад мөрдөгдөж байгаа стандартын үзүүлэлтүүдээр баталгаажуулж ажилладаг.



Зураг 13. Сорилт шинжилгээний лаборатори

Ажиллах хүчин:

“Тэжээлийн үйлдвэр болон Шувууны аж ахуйн цогцолбор” нь нийтдээ 200 ажилтантай. Ажилтан, ажиллагсадаа орон нутгаас бүрдүүлхийг эрмэлздэг. Ээлжийндээ 1 удаа бүх ажиллагсад компанийн журмын дагуу хооллоно.



2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| № | Ажиллах хүчин | Орон тоо | № | Ажиллах хүчин | Орон тоо |
|---------------------------|-------------------------------|----------|-------------------|-------------------------------------|------------|
| Үйлдвэрийн удирдлага | | 9 | Мэргэшсэн ажилчид | | 90 |
| 1 | Үйлдвэрийн дарга | 4 | 1 | Өндөглөгч байрны ажилтан | 34 |
| 2 | Менежер-Технолоич | 3 | 2 | Дэгдээхийн байрны ажилтан | 10 |
| 3 | Сав баглааны үйлдвэрийн дарга | 1 | 3 | Инкубаторын ажилтан | 5 |
| 4 | Тэжээлийн үйлдвэрийн дарга | 1 | 4 | Сав баглааны үйлдвэрийн ажилтан | 13 |
| Мэргэжлийн боловсон хүчин | | 12 | 5 | Халаалтын зуухны ажилтан, Харуул | 15 |
| 1 | Малын эмч | 2 | 6 | Тэжээлийн үйлдвэрийн ажилтан | 5 |
| 2 | Химич, микробиологич | 2 | 7 | Тогооч | 3 |
| 3 | Нярав | 4 | 8 | Жолооч | 4 |
| 4 | Инженер техникийн ажилтан | | 9 | Бордооны үйлдвэрийн ажилтан | 1 |
| 5 | ХАБЭА-н ажилтан | 2 | | Мэргэжлийн бус ажилчид | 7 |
| 6 | Инкубаторын малын эмч | 1 | 1 | Ачигч | 5 |
| 7 | Чанарын менежер | 1 | 2 | Үйлчлэгч | 2 |
| | | | | НИЙТ | 118 |

Ажиллах хоног: Цогцолборын нэгж хэсгүүд нь үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан ажиллах хоног нь харилцан адилгүй байдаг. Тухайлбал шувууны аж ахуй нь жилд 365 хоног тасралтгүй ажиллах бол үржлийн өндөг дарах инкубаторын цех нь төлөвлөлтөөс хамаарч жилд 130-220 хоног ажилладаг.

Хүснэгт 4.

Ажиллах хоног

| № | Үзүүлэлт | Хоног | Тэмдэглэл |
|---|----------------------|---------|--|
| 1 | Шувууны аж ахуй | 365 | |
| 2 | Инкубатор | 130-220 | Төлөвлөлтөөс хамаарна. |
| 3 | Сав баглааны үйлдвэр | 285 | Нийтээр амрах баяр, засвар үйлчилгээний өдрүүд 15-30 хоног зогсолт |
| 4 | Тэжээлийн үйлдвэр | 300 | |
| 5 | Бордооны үйлдвэр | 200 | Улирлаас шалгаалан 11 сарын 15-аас 3 сарын 20 зогсолт |

Цахилгаан, дулаан хангамж, хэрэглээ

Цахилгаан хангамж, хэрэглээ: Шувууны аж ахуйн цогцолбор нь төвийн цахилгаан шугам сүлжээнд холбогдсон бөгөөд 0.4кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамаас үйлдвэрийг цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Ослын үеийн дизель цахилгаан үүсгүүртэй.

Дулаан хангамж, хэрэглээ: Үйлдвэрийн хэрэгцээт уурыг уурын зуухаар, барилга, байгууламжийн дулааныг усан халаалтын зуухаар хангадаг.

Хүснэгт 5. Халаалтын зуухны мэдээлэл

| № | Зуухны марк | Тоо ширхэг | Зориулалт | Нүүрсний хэрэглээ, тн/жил | Хүчин чадал |
|---|-----------------|------------|---------------------|---------------------------|-------------------------|
| 1 | КВр-0.3 | 1 | Халаалтын зуух | 282.2 | 0.3МВт (Гкал дулаан/ц) |
| 2 | КВр-0.15 | 1 | Халаалтын зуух | 141.1 | 0.15МВт (Гкал булаан/ц) |
| 3 | DHZ1.4-85/66-АП | 1 | Халаалт, уурын зуух | 706.6 | 1.4тн уур/ц |
| 4 | DZL1-1.0-АП | 1 | Халаалт, уурын зуух | 327.6 | 1.0тн уур/ц |



2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| | | | | | |
|------|--------|---|---------------------|--------|------------------------|
| 5 | WH-200 | 1 | Халаалт, уурын зуух | 242.7 | 0.3МВт (Гкал дулаан/ц) |
| Нийт | | 5 | | 1700.2 | |



Зураг 14. Усан халаалтын зуух (КВр-0.3 болон КВр-0.15 маркийн зуух)

1.2. Орчны агаарын чанар

Төсөл хэрэгжүүлэгч нь ХУД 13-р хороо нь Агаарын чанар сайжруулах бүсийн 1-р бүс. 2020.09.28-ны өдөр “Түмэн шувуут” ХК-ийн “Шувууны аж ахуйн цогцолбор”-ын гадна агаарын чанар, физик бохирдлыг тодорхойлох ажлыг дараах аргачлалын дагуу хэмжилтийг Цаг уур орчны шинжилгээний газрын Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори хийв.

Хүснэгт 6. Агаарын чанарын хэмжилтийн дүн

| № | Сорьц авсан цэг | Хүхэрлэг хий (SO ₂), мг/м ³ | Азотын давхар исэл (NO ₂), мг/м ³ | Нийт тоосны агууламж, мг/м ³ | Дуу чимээ дБа |
|---|--------------------|--|--|---|---------------|
| 1 | Үйлдвэрийн хашаанд | 0.020 | 0.064 | 0.100 | 50 |
| “Агаарын чанарын стандарт” MNS 4585:2016 | | 0.450 | 0.200 | 0.500 | 60 |

Шинжилгээний үр дүнгээс харахад Шувууны аж ахуйн цогцолбор гадна агаар дахь SO₂, NO₂, нийт тоосны агууламж MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байна.

1.3. Хөрсний төлөв байдлын шинжилгээ:

Байгаль орчны төлөв байдлын судалгааны ажлын хүрээнд тус Шувууны аж ахуйн цогцолборын талбайгаас хөрсний химийн шинж чанар, механик бүрэлдэхүүн болон бохирдолыг тодорхойлох хөрсний дээжийг 2022.04.18-ны өдөр авч “Инженер геодез” ХХК Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

Хүснэгт 7. Хөрсний механик бүрэлдэхүүн

| Дээж авсан цэг | Механик ширхэгүүд (%-иар), Ширхэгийн хэмжээ (мм-ээр) | | | | | | |
|---------------------------------|--|-----------|-----------|------------|-------------|--------|-------|
| | Элс | | | Тоос | | Шавар | |
| | 1~0.25 | 0.25~0.05 | 0.05~0.01 | 0.01~0.005 | 0.005~0.001 | <0.001 | <0.01 |
| Дээж №1 ШАА-2 | 37.5 | 50.4 | 1.7 | 4.4 | 3.8 | 2.2 | 10.4 |
| Дээж №2 ШАА-1 | 29.8 | 50.2 | 10.0 | 2.1 | 5.0 | 3.0 | 10.0 |
| Дээж №2 Тэжээлийн үйлдвэр | 25.4 | 59.1 | 5.6 | 3.4 | 4.6 | 1.9 | 9.9 |



Хүснэгт 8. Хөрсний агрохимийн шинж чанар

| Дээж авсан цэг | Дээж авсан гүн, см | pH | Ялзмаг, % | Давс, % | ЦДЧ, dS/m | CaCO ₂ , % | Солилцох суурь, мг-экв/100гр | | Шим тэжээлийн элементүүд, мг/100гр | |
|---------------------------|--------------------|------|-----------|---------|-----------|-----------------------|------------------------------|------------------|------------------------------------|------------------|
| | | | | | | | Ca ⁺² | Mg ⁺² | P ₂ O ₅ | K ₂ O |
| Дээж №1 ШАА-2 | 0~20 | 8.57 | 0.78 | 0.02 | 0.054 | 0.00 | 9.1 | 4.4 | 0.7 | 14 |
| Дээж №2 ШАА-1 | 0~20 | 6.44 | 2.22 | 0.03 | 0.127 | 0.00 | 9.1 | 4.3 | 3.7 | 28 |
| Дээж №3 Тэжээлийн үйлдвэр | 0~20 | 7.38 | 0.74 | 0.02 | 0.040 | 0.00 | 8.0 | 4.7 | 2.3 | 13 |

Дээж №1 Шувууны аж ахуй-2: Хөрсний задлан шинжилгээний дүнгээр үйлдвэрийн төв хэсгийн хөрс нь сулавтар шүтлэг орчинтой, хөрсний үржил шимийн ерөнхий үзүүлэлт болох ялзмагийн агууламж бага, хөрсний солилцох сууриудын нийлбэр (Ca+Mg) бага агууламж, ургамалд ашиглагдах тэжээлийн нэмэлтүүд болох нитратын үзүүлэлтийн хариу гараагүй, хөдөлгөөнт фосфор бага, солилцох кали бага, маш бага зэргийн давсжилттай, цахилгаан дамжуулах чадваргүй хөрс байна.

Дээж №2 Шувууны аж ахуй-1: Хөрсний задлан шинжилгээний дүнгээр үйлдвэрийн хойд хэсгийн хөрс нь сулавтар хүчиллэг орчинтой, хөрсний үржил шимийн ерөнхий үзүүлэлт болох ялзмагийн агууламж өндөр, хөрсний солилцох сууриудын нийлбэр (Ca+Mg) бага агууламж, ургамалд ашиглагдах тэжээлийн нэмэлтүүд болох нитратын үзүүлэлтийн хариу гараагүй, хөдөлгөөнт фосфор ихэвтэр, солилцох кали дундаж, маш бага зэргийн давсжилттай, цахилгаан дамжуулах чадвар бага хөрс байна.

Дээж №3 Тэжээлийн үйлдвэр: Хөрсний задлан шинжилгээний дүнгээр үйлдвэрийн урд хэсгийн хөрс нь сулавтар шүтлэг орчинтой, хөрсний үржил шимийн ерөнхий үзүүлэлт болох ялзмагийн агууламж бага, хөрсний солилцох сууриудын нийлбэр (Ca+Mg) бага агууламж, ургамалд ашиглагдах тэжээлийн нэмэлтүүд болох нитратын үзүүлэлтийн хариу гараагүй, хөдөлгөөнт фосфор дундаж, солилцох кали бага, маш бага зэргийн давсжилттай, цахилгаан дамжуулах чадваргүй хөрс байна.

1.4. Хэрэглээний усны чанар:

2023.04.18-ны өдөр “Түмэн шувуут” ХК-ийн “Шувуун аж ахуй, Тэжээлийн үйлдвэр”-ийн хэрэглээний усны чанарыг тодорхойлох зорилгоор дээж авч “Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв.

Хүснэгт 9. Усны химийн шинжилгээний дүн

| Анион | MNS 0900:2018 | 1дм ³ -д байгаа | | | Катион | MNS 0900:2018 | 1дм ³ -д байгаа | | |
|-------|---------------|----------------------------|----------|----------|--------|---------------|----------------------------|----------|----------|
| | | мг/л | мг-экв/л | мг-экв/% | | | мг/л | мг-экв/л | мг-экв/% |

Их булаг Шувууны аж ахуй-2 худгийн ус №1

| | | | | | | | |
|-----------------|-------|------|------|---------------------------------|-------|------|-------|
| Cl ⁻ | 24.11 | 0.68 | 8.36 | Na ⁺ +K ⁺ | 66.67 | 2.90 | 35.70 |
|-----------------|-------|------|------|---------------------------------|-------|------|-------|



2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| | | | | | | | |
|-------------------------------|--------|------|--------|------------------------------|--------|------|--------|
| SO ₄ ²⁻ | 92.70 | 1.93 | 23.77 | NH ₄ ⁺ | 0.10 | 0.01 | 0.07 |
| NO ₃ ⁻ | 25.46 | 0.41 | 5.06 | Ca ²⁺ | 60.12 | 3.00 | 36.94 |
| NO ₂ ⁻ | 0.03 | 0.00 | 0.01 | Mg ²⁺ | 26.75 | 2.20 | 27.09 |
| CO ₃ ²⁻ | 6.00 | 0.10 | 1.23 | Fe ²⁺ | 0.30 | 0.02 | 0.20 |
| HCO ₃ ⁻ | 305.10 | 5.00 | 61.57 | Fe ³⁺ | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 453.39 | 8.12 | 100.00 | Дүн | 153.94 | 8.12 | 100.00 |

Туул тосгон Шувууны аж ахуй-1 худгийн ус №2

| | | | | | | | |
|-------------------------------|--------|-------|--------|---------------------------------|--------|-------|--------|
| Cl ⁻ | 34.74 | 0.98 | 9.06 | Na ⁺ +K ⁺ | 101.13 | 4.40 | 40.70 |
| SO ₄ ²⁻ | 126.30 | 2.63 | 24.34 | NH ₄ ⁺ | 0.10 | 0.01 | 0.05 |
| NO ₃ ⁻ | 30.62 | 0.49 | 4.57 | Ca ²⁺ | 74.15 | 3.70 | 34.25 |
| NO ₂ ⁻ | 0.03 | 0.00 | 0.01 | Mg ²⁺ | 32.83 | 2.70 | 24.99 |
| CO ₃ ²⁻ | 6.00 | 0.10 | 0.93 | Fe ²⁺ | 0.00 | 0.00 | 0.00 |
| HCO ₃ ⁻ | 402.73 | 6.60 | 61.10 | Fe ³⁺ | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 600.42 | 10.80 | 100.00 | Дүн | 208.21 | 10.80 | 100.00 |

Хужирбулан ам Агрофийд тэжээлийн үйлдвэр худгийн ус №3

| | | | | | | | |
|-------------------------------|--------|-------|--------|---------------------------------|--------|-------|--------|
| Cl ⁻ | 35.45 | 1.00 | 9.29 | Na ⁺ +K ⁺ | 90.77 | 3.95 | 36.70 |
| SO ₄ ²⁻ | 122.90 | 2.56 | 23.80 | NH ₄ ⁺ | 0.10 | 0.01 | 0.05 |
| NO ₃ ⁻ | 30.62 | 0.49 | 4.59 | Ca ²⁺ | 78.16 | 3.90 | 36.27 |
| NO ₂ ⁻ | 0.03 | 0.00 | 0.01 | Mg ²⁺ | 35.26 | 2.90 | 26.97 |
| CO ₃ ²⁻ | 6.00 | 0.10 | 0.93 | Fe ²⁺ | 0.00 | 0.00 | 0.00 |
| HCO ₃ ⁻ | 402.73 | 6.60 | 61.38 | Fe ³⁺ | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 597.73 | 10.75 | 100.00 | Дүн | 204.29 | 10.75 | 100.00 |

Хүснэгт 10. Усны физик шинж чанар

| № | Сорьц авсан цэг | Өнгө градус | Үнэр | Амт | Булингар, NTU | Хуурай үлдэгдэл, мг/л | pH | Ерөнхий хагуулаг, мг-экв/л |
|----------------------|-------------------|-------------|--------|------|---------------|-----------------------|---------|----------------------------|
| 1 | Их булаг ШАА-2 | 0-Үгүй | 0-Үгүй | Үгүй | Тунгалаг | 458.0 | 8.26 | 5.20 |
| 2 | Туул тосгон ШАА-1 | 0-Үгүй | 0-Үгүй | Үгүй | Тунгалаг | 652.0 | 8.22 | 6.50 |
| 3 | Агрофийд ТҮ | 0-Үгүй | 0-Үгүй | Үгүй | Тунгалаг | 626.0 | 8.23 | 6.80 |
| MNS 0900:2018 | | 20 | - | - | 5.0 | 1.0 | 6.5~8.5 | 7.0 |

1.5. Хог хаягдалын эх үүсвэр, хэмжээ

Энгийн ахуйн хог хаягдал: Төслийн үйл ажиллагаанаас цогцолборын нийт 80-110 ажилчдаас жилд ойролцоогоор 14.6-20.0тн (2021-2026 оны хооронд) хатуу, 1022.0~1405.2м³ шингэн хаягдал ялгарах тооцоотой.

Хог хаягдал дахин ашиглалт, боловсруулалт хэмжээ

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал: Үйлдвэрлэлийн процессоос жилд ойролцоогоор 9170.8~10671.8тн хаягдал үүсэх боломжтойгоос сүүлийн жилүүдэд шувууны сангас, өндөгний хальс, цаасан хаягдал зэрэг нийт 5.7мян.тн хатуу хог хаягдлыг өөрийн үйлдвэртэй дахин боловсруулсан ба 3.4-4.9мян.тн сангасыг ХУД-ийн 12, 13-р хороонд хүлэмжийн аж ахуй эрхэлдэг хувь хүн, ААНБ-ууд (“Баялаг жимс” ХХК, “Вагро” ХХК, “Дэвшил трейд” ХХК, “ГБТ трейдинг” ХХК) авч хэрэглэдэг.

Сав баглааны үйлдвэрт 30.9мян.м³ ус дахин ашигласан.

Тус үйлдвэр нь хог хаягдал бууруулах дахин ашиглах чиглэлээр үйлдвэрээ өргөтгөн сав баглааны үйлдвэрт хаягдал цаас, цаасан хайрцаг худалдан авч боловсруулан өндөгний үүр



2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

үйлдвэрлэдэг, өндөглөгч тахианы сангас, өндөгний хальсыг боловсруулан бордоо үйлдвэрлэдэг. Ажилчдын ахуйн болон бусад хатуу хаягдлыг үйлдвэрийн нэгдсэн хогийн цэгт хуримтлуулан дүүргийн хог тээврийн тусгай зөшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулан зайлуулж байна.


Шингэн хаягдал

Хаягдал ус: Технологигоос хаягдах (өндөг үржүүлэх инкубатор болон тахианы мах боловсруулах үйлдвэр нь жилд 4-5 удаа ажилладаг) 4.7~5.1 мян.м³ хаягдал ус 20-40тн хөрсөнд шингэхгүй, битүү цементэн ёмкостод хуримтлуулж тухай бүр бохир ус тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий компанитай хийсэн гэрээний дагуу соруулж зайлуулдаг.

Ахуйн болон угаалга цэвэрлэгээнээс үүсэх 1.0~1.4 мян.м³ хаягдал усыг шувуун фабрикийн төвийн бохирын шугаманд нийлүүлэн улирал тутам ус бохирдуулсны төлбөр төлдөг байна. Дараах зургуудад үйлдвэр, объект тус бүрийн цэвэр усны хэрэглээ, хаягдал усны гаралтыг харуулав.



Зураг 15. Хог ангилан ялгах сав



Зураг 16. Сангасны (компост бордоо) үйлдвэр



Зураг 17. Хаягдал бохир ус хуримтлуулах сав болон бохирыг соруулж буй байдал



ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Хүснэгт 11. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

| № | Нөлөөллийн эх үүсвэр | Сөрөг нөлөөлөл |
|----|--|---|
| 1 | Зуухны утаатай хамт хаягдах бохирдуулагч бодис | Түлшний чанар болон шаталтаас хамааран агаарт хаягдах бохирдуулах бодисын хэмжээ нэмэгдэх |
| 2 | | Зуухны бүрэн бус ажиллагаанаас хамааран яндангаар хаягдах тоосны агууламж нэмэгдэх |
| 3 | Үнс иүүрснээс босох тоосжилт | Зуухны үнсийг үед ажлын байрны дотор тоосжилт болон дуу чимээ ихсэх |
| 4 | | Нүүрс болон үнсний талбайгаас тоос босож орчны агаарын чанарт нөлөөлөх |
| 5 | Физик бохирдол үнэрийн бохирдол | Ажлын байрны агааржуулалт муугаас агаарын чанар муудах |
| 6 | | Үйлдвэрийн үйл ажиллагаа, ялангуяа мха боловсруулалтаас гарсан бохир ус, тосны хаягдал орчинд эвгүй үнэр тархах |
| 7 | | Хаягдал сангас орчны агаарт тархаж үнэрийн бохирдол үүсгэх |
| 8 | | Үйлдвэрийн бохир усны сангийн үнэр тархах |
